



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар A/100

Батноров сум

「 Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэхийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 69 дүгээр зүйл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10, 28.1.12 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр "Цаг хугацааны хуваарь батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийн санал авах ажиллагаатай холбогдуулан сумын хэмжээнд 2025 оны 06 дугаар сарын 21, 22, 23-ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Захирамжид дурдсан хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг согтууруулах ундаа худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (А.Борчулуун), Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (А.Эрдэнэтуяа), Хэсгийн төлөөлөгч (Г.Ганбаяр), Хүнс, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ц.Мөнхбат)-т тус тус даалгасугай.

ДАРГА



ГОТГОНБАЯР